

# Налайх дүүрэг "Хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн ба хэрэгцээ шаардлага" Түргэвчилсэн судалгаа

2022 оны 7-р сар



© З.Эрдэнэ

# Агуулга

Удиртгал ба аргачлал .....	1
Мэдээллийн дүн шинжилгээ.....	2
1.1 Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм.....	2
1.2 Ирсэн иргэд.....	3
1.3 Явсан иргэд.....	3
1.4 Хөдөлмөр эрхлэлт.....	4
1.5 Санхүүгийн нөхцөл байдал.....	5
1.6 Тулгамдаж буй асуудал, аюулгүй байдал.....	6
1.7 Үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц.....	10
1.8 Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж.....	14
1.9 Тээвэр, замын хөдөлгөөний нөхцөл байдал.....	15
1.10 Хүүхэд болон боловсрол.....	16

# Удиртгал ба аргачлал

## Удиртгал

Дүүргийн түвшний энэхүү тайланд 2022 оны 3-р сард Улаанбаатар хотын хэмжээнд хүн ам, шилжилт хөдөлгөөн, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох шуурхай үнэлгээнд тусгагдсан үндсэн болоод сэдэвчилсэн бүх чиглэлийн тойм мэдээллийг багтаасан болно.

Энэхүү тайлан нь Налайх дүүргийн хэмжээнд найман үндсэн сэдвийг хамарсан судалгааг багтаасан; тухайлбал, хүн амын суурь тоон үзүүлэлт, хүн ам зүй, ирсэн болон явсан иргэд (шилжилт хөдөлгөөн), хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд ба аюулгүй байдал, үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, хүүхэд болон боловсрол гэх мэт. Мэдээллийг дүүргийн нутаг дэвсгэр, хүний нөөц, засаг захиргааны нэгжийн харилцааны талаарх мэдлэг өндөртэй мэдээлэл нэгтгэгчид болох хэсгийн ахлагч нартай ярилцлага хийх замаар олж авсан. Энэхүү судалгааны үндэслэл, хэрэгцээ шаардлагын талаар дэлгэрэнгүй мэдээллийг Улаанбаатар хотын дэлгэрэнгүй тайлангаас авч үзнэ үү.

## Аргачлал

Энэхүү тайланд ОУШХБ-ын Шилжих хөдөлгөөнийг тандах матриц (ДТМ)-ийн нэгжээс боловсруулсан хөдөлгөөнийг тандах (МТ) аргачлалыг ашигласан болно.

Судалгаанд хөдөлгөөнийг тандах (МТ) аргачлалыг ашигласан Улаанбаатар хотын хамгийн жижиг засаг захиргааны нэгж болох хэсгийн түвшинд хэсгийн ахлагч нараас мэдээллийг цуглуулав. Хэсгийн ахлагч нар иргэдтэй ярилцах, ажиглалт хийх болон өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан, харилцаа холбооны хэрэгслүүдийг ашиглан тоон мэдээллийг нягтлах, баталгаажуулах ажлыг хийхээр төлөвлөсөн. Хэсгийн ахлагч нарыг хүн амын суурь тоон үзүүлэлт, шилжин ирэгсэд ба явагсад, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, аюулгүй байдал, үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц, ногоон байгууламж, хүүхэд ба боловсрол гэсэн найман үндсэн сэдвийг багтаасан судалгааны асуулгыг бөглөхийг хүссэн юм.

Хэсгийн ахлагч нар Кобо программ хамгамжаар дамжуулан тоон мэдээллийг гар утас эсвэл таблет, компьютер ашиглан бөглөж илгээсэн. Хэсгийн ахлагч нарыг ДТМ судалгааны аргачлал, судалгааны асуулга, түүнийг нөхөхтэй холбоотой танхимын сургалтад бүрэн хамруулсан. Түүнчлэн ДТМ-ийн баг мэдээлэл цуглуулах явцад үүссэн аливаа асуулт, асуудалд цаг тухайд нь хариу өгч бэлэн байдалд ажилласан юм.


Өгөгдөл оруулах үйл явц албан ёсоор хаагдмагц ДТМ-ийн баг бүрэлдэхүүн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлсэн бөгөөд өгөгдөл оруулахад гарч болзошгүй алдаа, тоон мэдээллийн зөрүү, давхардал зэргийг илрүүлэхийн тулд өгөгдлийн хяналтын шатанд чанарын баталгаажуулалтын шалгалтыг хийсэн. Өгөгдөлтэй холбоотой аливаа асуудал илэрсэн тохиолдолд ДТМ-ийн баг тодруулга авахаар хэсгийн ахлагч нартай утсаар холбогдож тоон мэдээллийг тодруулж, баталгаажуулсан байна. Бүх хяналт, шалгалтыг хийж дууссаны дараа мэдээлэлд дүн шинжилгээ хийх үе шатанд шилжсэн. Бүх судалгааны үр дүнг хэсгийн түвшинд дүн шинжилгээ хийж, дараа нь дүүргийн болон хотын хэмжээнд нэгтгэн дүгнэв. Иймээс дүүрэг, хотын түвшинд энэхүү тайланд тусгагдсан аливаа үр дүнг хэсгийн түвшинд ч авах боломжтой гэдгийг дурдах нь зүйтэй юм.

Хязгаарлагдмал байдал, судалгааны аргачлалын талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг Улаанбаатар хотын хэмжээний нэгдсэн тайлангаас үзнэ үү.




## 1. МЭДЭЭЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ ШИНЖИЛГЭЭ-НАЛАЙХ ДҮҮРЭГ

### 1.1 Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм



Хүн ам зүй (эзлэх хувь)




Үнэлгээ хийх үед (2022 оны 3-р сар) Налайх дүүрэгт 41,628 иргэн буюу 10,405 өрх амьдарч байв. Үүнээс 50 хувь нь эрэгтэй, 50 хувь нь эмэгтэй байв. Хүн амын 34% нь насанд хүрээгүй гэж бүртгэгдсэн, 10 хувь нь 0-5 насныхан, 24% нь 6-17 насныхан байна. Хүн амын 60 хувийг 18-65 насны насанд хүрэгчид, 6 хувийг өндөр настан (65-аас дээш насныхан) эзэлж байна.

Нийтдээ 649 хүн архаг хууч эсвэл хүнд өвчтэй (хүн амын 1.6%), 234 эмэгтэй (эмэгтэйчүүдийн 1.1%) жирэмсэн гэж бүртгэгджээ.

Налайх дүүрэг 8 хороо, 50 хэсэгтэй. Дүүргийн хүн амын бараг таван хүн тутмын нэг нь оршин суудаг 4-р хороо хамгийн олон хүн амтай, дараа нь (19%), 7-р хороо (15%), 8-р хороо (14%) орж байна.


Хүн ам зүйн тойм хүйсээр, хороогоор (эзлэх хувь)



### 1.2 Ирсэн иргэд<sup>2</sup>

Налайх дүүрэгт 2021 онд нийт 661 өрх буюу 2,048 иргэн ирсэн. 2021 онд Улаанбаатар хотын хэмжээнд ирсэн нийт иргэдийн 1.7% нь Налайх хотод байгаагаас дийлэнх нь 8-р хороо (20%), 2-р хороо (17%), 7-р хороо (31%-)нд бүртгэгдсэн байна. Энэ дүүрэгт ирсэн гол шалтгаан нь гэр бүл (38%), эдийн засаг (17%), мөн боловсролын (16%) шалтгаан байна.


Ирсэн иргэд хамгийн их бүртгэгдсэн хороо (ирсэн иргэдийн эзлэх хувь)




### 1.3 Явсан иргэд

2021 онд Налайх дүүргээс нийт 758 өрх буюу 2,872 иргэн явсан. Улаанбаатар хотын хэмжээнд 2021 онд нийт шилжин явагсдын 3.3 хувь нь Налайх дүүргээс гарсан байна. Хамгийн өндөр хувь нь 2-р хороо (40%), 7-р хороо (23%), 1-р хороо (13%-)аас гарчээ. Ерөнхийдөө энэ дүүргээс явах болсон үндсэн шалтгаан нь гэр бүлийн шалтгаан (44%) байв.

Явсан иргэд хамгийн их бүртгэгдсэн хороо (ирсэн иргэдийн эзлэх хувь)



Ирсэн, явсан үндсэн шалтгаанууд (эзлэх хувь)




<sup>2</sup> Ирсэн иргэд гэдэг нь Улаанбаатар хотын дотор эсвэл хотын гаднаас ирсэн эсэхээс үл хамааран Улаанбаатар хотын аль нэг байршилд оршин суухаар ирсэн иргэн, айл өрхийг хэлнэ. Явсан иргэд гэдэг нь Улаанбаатар хотын аль нэг байршилаас явсан эсэхийг үл хамааран явсан иргэн, айл өрхийг хэлнэ.

## 1.4 Хөдөлмөр эрхлэлтийн байдал

Налайх дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зонхилох салбар нь уул уурхай, олборлолт, бусад аж үйлдвэрийн үйл ажиллагаа (хэсгүүдийн 20%), дараа нь бөөний болон жижиглэнгийн худалдаа (хэсгүүдийн 18%), мал аж ахуй/хөдөө аж ахуй/ойн аж ахуй (хэсгүүдийн 14%) байна. Иймд Налайх дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн салбарууд хотын нийтлэг хандлагаас ихээхэн ялгаатай байна. Уул уурхай, олборлолт, бусад үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь хэсгүүдийн ердөө 6 хувийг, мал аж ахуй/хөдөө аж ахуй/ойн аж ахуй нь бүр бага, хэсгүүдийн 3%-ийг бүрдүүлдэг байна. Уул уурхай, олборлолт болон бусад үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хамгийн түгээмэл хороод нь 7-р хороо (хэсгүүдийн 57%), 4-р хороо (хэсгүүдийн 56%) юм. 1,773 хүн амтай 6-р хорооны бүх хэсэгт мал аж ахуй/хөдөө аж ахуй/ойн аж ахуйг үндсэн хөдөлмөр эрхлэлтийн салбар гэж мэдээлжээ. Нийт 9,247 хүн (дүүргийн хүн амын 22%) уул уурхай, олборлолт, бусад аж үйлдвэрийн үйл ажиллагаа нь хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар болох хэсгүүдэд оршин суудаг байна. 7,680 хүн (дүүргийн хүн амын 18%) бөөний болон жижиглэнгийн худалдаа зонхилдог хэсгүүдэд, 3,733 хүн (дүүргийн хүн амын 9%) мал аж ахуй/хөдөө аж ахуй/ойн аж ахуй зонхилдог хэсгүүдэд оршин суудаг гэж мэдээлжээ.


Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар (хэсгийн эзлэх хувь)




Хөдөлмөр эрхлээгүй хүн ам (18-64 насны иргэдийн эзлэх хувь)



Хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь, хороогоор (18-64 насны иргэдийн эзлэх хувь)



Хөдөлмөр эрхлэлтийн төрөл (хэсгийн эзлэх хувь)



Хувиараа хөдөлмөр эрхлэлт

Налайх дүүргийн хэмжээнд 18-64 насны 8,044 хүн хөдөлмөр эрхлээгүй байгаа нь насанд хүрсэн хүн амын 32 хувийг эзэлж байна. Энэ дүүрэгт ажилгүйдлийн түвшин хотын дундаж болох 30 хувиас хоёр хувийн пунктээр өндөр байна. Хөдөлмөрийн насны хүн амын гуравны хоёр гаруй хувь нь ажилгүй 6-р хороо (69%), 3-р хороо (62%), 1-р хороо (49%-нд хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь хамгийн өндөр байна. Тэдгээр гурван хороонд хөдөлмөрийн насны нийт 7,577 иргэн байгаагаас 4,386 иргэн хөдөлмөр эрхлээгүй гэсэн мэдээлэл байна. Харин эсрэгээрээ хөдөлмөрийн насны хүн амын 99 хувь (3,606 хүнээс 3,559) хөдөлмөр эрхэлдэг 8-р хороонд ажилгүйдэл хамгийн бага, дараа 2-р хороо (85%), 4-р хороо (77%) оржээ. Тэдгээр гурван хороонд хөдөлмөрийн насны нийт 11,232 иргэний 9,682 нь хөдөлмөр эрхэлдэг гэсэн мэдээлэл байна.

Налайх дүүргийн хэмжээнд хэсгүүдийн 52 хувьд хувийн хэвшил, 10 хувьд хувиараа хөдөлмөр эрхлэлт, 28 хувьд төрийн алба зонхилж байна. Налайх дүүрэг нь Улаанбаатар хотын бусад дүүрэгтэй харьцуулахад хувийн хэвшил хамгийн бага гэдгээрээ гуравт ордог дүүрэг юм. Мөн төрийн албанд хөдөлмөр эрхэлдэг хүн ам дунджаас илүү байгааг мэдээлжээ (хотын дундаж хэсгээс 13 пунктээр өндөр). Хувийн хэвшил 8-р хороо (хэсгүүдийн 83%), 7, 3, 1-р хороодод (хэсэг тус бүр 57%) хамгийн түгээмэл байна. Хувийн хэвшил хамгийн түгээмэл 8-р хороо мөн хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн маш өндөр хувийг (99%) эзэлж байгааг мэдээлсэн нь хувийн хэвшилд ажиллах боломж өндөр байснаар хөдөлмөр эрхэлдэг хүний тоо олон болдогыг харуулж байна. Төрийн алба 5-р хороо (хэсгүүдийн 60%), 3, 7-р хороодод (хэсэг тус бүр 43%) хамгийн түгээмэл хөдөлмөр эрхлэлтийн төрөл байна.

### 1.5 Санхүүгийн нөхцөл байдал

Энэ хэсэгт орлогын болон хүнсэнд зарцуулах зардлын бууралттай холбоотой асуудлаар мэдээлэгчийн ажиглалтыг авч үзэх замаар санхүүгийн байдлыг судалсан болно.

Нийтдээ Налайх дүүргийн нутаг дэвсгэрт байгаа хэсгүүдийн 34 хувьд нь мэдээлэгчид мэдээлэл цуглуулахаас өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд айл өрхүүд хангалттай идэх хоолгүй байна гэсэн санаа зовнилоо илэрхийлсэн гэж мэдээлсэн бөгөөд энэ нь нийт 14,296 хүнд нөлөөлжээ. Энэ үзүүлэлт нь хотын дундаж болох 29 хувиас таван хувийн пунктээр өндөр байна. Үүнд 4-р хороо хамгийн их өртөж байгаа бөгөөд хэсгүүдийн 89 хувьд нь мэдээлэгчид хангалттай идэх хоолгүй байна гэсэн санаа зовнил байгааг мэдээлжээ.

Хэсгүүдийн 46 хувьд нь мэдээлэгчид мэдээлэл цуглуулахаас өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд айл өрхүүд хүнсний хэрэглээгээ багасгасан тухай дам яриа сонссон гэж мэдээлсэн бөгөөд энэ нь нийт 18,752 хүнд нөлөөлсөн байна. Энэ үзүүлэлт нь хотын дундаж болох 34 хувиас 12 хувийн пунктээр өндөр байна. Үүнд 4-р хороо хамгийн их өртөж байгаа бөгөөд бүх хэсгийн мэдээлэгчид айл өрхүүд хүнсний зардлаа бууруулж байгаа тухай мэдээлжээ.

Хүнсний хүртээмжтэй байдал (хэсгийн эзлэх хувь)


#### Хүнсний хэрэглээ хангалтгүй байгаад санаа зовних




#### Хүнсний хэрэглээгээ багасгасан



Сүүлийн 4 долоо хоногт орлого нь буурсан иргэд (хэсгийн эзлэх хувь)



Сүүлийн 4 долоо хоногт бүх орлогоо алдсан иргэд (хэсгийн эзлэх хувь)




Налайх дүүргийн нутаг дэвсгэр дэх хэсгүүдийн 78 хувьд нь мэдээлэл цуглуулахаас өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд оршин суугчдын талаас бага буюу бараг хэн ч орлого буураагүй гэж мэдээлсэн байна. Гэхдээ хэсгүүдийн 22 хувьд нь оршин суугчдын тал буюу талаас илүү хувь нь орлогоо алдаж, энэ нь 10,279 хүнд нөлөөлсөн байна. Хэсгүүдийн 94 хувьд нь мэдээлэл цуглуулахаас өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд оршин суугчдын талаас бага буюу бараг хэн ч бүх орлогоо алдаагүй гэж мэдээлсэн байна. Гэхдээ хэсгүүдийн 16 хувьд нь бараг тал хувь нь бүх орлогоо алдаж, энэ нь 2,370 хүнд нөлөөлжээ.

### 1.6 Тулгамдаж буй асуудал болон аюулгүй байдал

Налайх дүүргийн хэмжээнд хамгийн тулгамдсан асуудал нь санхүү, эдийн засгийн тогтворгүй байдалтай холбоотой байна. Хамгийн их мэдээлж байгаа тулгамдсан асуудал нь орлого хангалтгүй (хэсгүүдийн 38%-д мэдээлсэн), дараа нь тухайн хэсгийн хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь (34%), өр зээл (16%) юм. Орлого хангалтгүй байна гэсэн санаа зовнил 7-р хороонд хамгийн их бүртгэгдсэн бөгөөд хэсгүүдийн 86 хувьд мэдээлжээ.

Тулгамдаж буй асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




Налайх дүүргийн хэмжээнд иргэд амьжиргаа ажлын байр/орлого бий болгох боломж (40%), авто машины зогсоол (20%), орон сууц (12%) зэрэг үйлчилгээг авахад хамгийн хүндрэлтэй байжээ. 4, 8 дугаар хорооны хэсгүүдийн 67 хувьд нь амьжиргаа ажлын байр, орлого бий болгох боломж нь нэн тэргүүнд анхаарах асуудал байсан бол 2-р хорооны хэсгүүдийн 80 хувьд нь авто машины зогсоолтой болох асуудал хамгийн анхаарал татсан асуудал байв.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгамдаж буй гол бэрхшээл нь тусгай зориулалтын эмнэлгийн тусламж үйлчилгээ дутмаг (42%), дараа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай тээврийн үйлчилгээ дутмаг (35%) байна.




Хүндрэлтэй байдаг үйлчилгээ (хэсгийн эзлэх хувь)




Аюулгүй байдал, хороогоор

Оноо: 1= маш муу, 2= муу, 3= дундаж, 4= сайн, 5= маш сайн



Аюулгүй байдлыг хөндсөн асуудал гарсан эсэх (хэсгийн эзлэх хувь)


Аюулгүй байдлыг хөндсөн асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




## 1.7 Дэд бүтэц, үйлчилгээ

### УС

Усны хэрэглээгүй байгаа хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Устай холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




### ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ

Цахилгааны хэрэглээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Цахилгааны хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




### ХООЛ, ХҮНС

Хүнсний бүтээгдэхүүн хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Хүнсний бүтээгдэхүүн хүрэлцээтэй тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




### ОРОН БАЙР

Орон байрны хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)





Орон байртай холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




## 1.7 Дэд бүтэц, үйлчилгээ


### ХҮНСНИЙ БУС ЗҮЙЛС




### ИНТЕРНЭТ



### ЭРҮҮЛ МЭНД



### УХААЛАГ УТАС






## 1.8 Ногоон байгууламж

Мэдээлэл нэгтгэгчээс өөрийн хэсгийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанарт нэгээс тав хүртэл, нэг нь маш муу, тав нь маш сайн гэсэн үнэлгээ өгөхийг хүссэн. Налайх дүүрэгт нийт өрхийн ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн чанар нийслэлийн дунджаас бага байсан бол хувийн хэвшлийн ногоон байгууламжийн чанар дундаж байна. Өрхийн ногоон байгууламжийн чанар 7-р хороонд хамгийн өндөр (3.0), 8 дугаар хороонд (1.5) хамгийн бага байна. Хувийн хэвшлийн ногоон байгууламжийн чанар 1-р хороонд хамгийн өндөр (3.3), 8-р хороонд (2.5) хамгийн бага байна. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн чанар 7-р хороонд хамгийн өндөр (3.3), 8-р хороонд хамгийн бага (1.5) байна.


Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар  
(хэсгийн эзлэх хувь %)

Оноо: 1= маш муу, 2= муу, 3= дундаж, 4= сайн, 5= маш


Өрхийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар



Хувийн хэвшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар




Нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар




	Өрхийн ногоон байгууламж	Хувийн хэвшлийн ногоон байгууламж	Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж
Хороо #1	2.9	3.3	1.7
Хороо #2	2.8	3.2	3.0
Хороо #3	2.1	2.6	2.3
Хороо #4	2.8	3.2	2.4
Хороо #5	2.2	2.8	2.4
Хороо #6	2.5	3.0	2.3
Хороо #7	3.0	2.9	3.3
Хороо #8	1.5	2.5	1.5

## 1.9 Зам тээвэр ба хөдөлгөөн

Хувийн тээврийн хэрэгсэлгүй өрх (хэсгийн эзлэх хувь )



Тээврийн үндсэн аргууд (хэсгийн эзлэх хувь)



Замын хөдөлгөөнтэй холбоотой үндсэн асуудлууд (хэсгийн эзлэх хувь %)



Налайх дүүрэгт такси үйлчилгээ зонхилох тээврийн хэрэгслэл бөгөөд нийт иргэдийн 52 хувь нь хүн амын тал болон түүнээс дээш хувь нь хувийн тээврийн хэрэгсэлгүй гэж хариулсан байна. Замын хөдөлгөөнтэй холбоотой хамгийн хүндрэлтэй асуудал 5-р хороонд (80%) авто машины зогсоол дутмаг (30%), дараа нь хүүхдүүд тоглох нийтийн талбай дутагдалтай байгаа нь хамгийн их байгаа нь 4-р хороо (56%) гэж бүртгэгдсэн байна.



© Y.Одбаяр

Уг тайлангийн үр дүн, дүгнэлт нь зөвхөн судалгааны багийн байр суурийг илэрхийлэх бөгөөд ОУШХБ, түүний гишүүн улсууд, Швейцарын хөгжлийн агентлаг болон бусад хандивлагчдын байр суурийг илэрхийлэхгүй болно. Тайлангийн туршид ашигласан тэмдэглэгээ болон материалын танилцуулга нь аливаа улс орон, нутаг дэвсгэр, хот, бүс нутгийн эрх зүйн байдлын талаар ОУШХБ-ын зүгээс ямар нэгэн үзэл бодлоо илэрхийлэх, эсхүл түүний эрх баригчид, хил хязгаарыг илэрхийлээгүй болно.

ОУШХБ нь шилжин суурьшигчид, хөдөлгөөнт хүн ам болон нийгэмд тустай, хүмүүнлэг, аюулгүй, цэгцтэй шилжилт хөдөлгөөний зарчмыг баримтлан ажилладаг. ОУШХБ нь засгийн газар хоорондын байгууллага, олон улсын хамтын нийгэмлэгийн түншүүдтэйгээ дараах зорилтын хүрээнд хамтран ажилладаг. Үүнд: Шилжилт хөдөлгөөний үйл явц дахь сорилтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх; шилжилт хөдөлгөөний асуудлын талаар мэдлэг мэдээллээ дээшлүүлэх; шилжилт хөдөлгөөнөөр дамжуулан нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих; мөн шилжин суурьшигчдын нэр төр, сайн сайхныг дээдлэх зэрэг болно.


Энэхүү тайлан нь Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэйгээр, ОУШХБ-аас хэрэгжүүлж буй “Монгол Улс дахь дотоод шилжилт хөдөлгөөнийг ойлгож, удирдах нь” төслийн хүрээнд хийгдэж буй ажлуудаас гаргаж буй үр дүнгийн нэг хэсэг юм. Энэхүү төслийн зорилго нь Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицыг (ДТМ) ашиглан Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөн, хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх замаар нотолгоонд суурилсан томъёолол, хэрэгжилтийг бэхжүүлэн бататгахад оршино. Судалгааны аргачлал, арга зүй, дүн шинжилгээ, тайланг загварчлах ажлыг ОУШХБ-ын ДТМ хариуцсан ОУ-ын зөвлөх Витторио Бруни, дотоодын зөвлөх Ганбатын Гэрэлтогтох, туслах ажилтан Болор-эрдэний Маналцогзолын хамт боловсруулсан болно. Судалгааны асуулгыг ОУШХБ-ын баг, НЗДТГ-ын оролцоотойгоор боловсруулсан байна. Судалгааны мэдээллийг ОУШХБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн алба болон Глобал ДТМ-ийг дэмжих багийн удирдлагуудын техникийн дэмжлэгтэйгээр Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицын (ДТМ) хэрэглүүрийг ашиглан цуглуулж, дүн шинжилгээ хийсэн болно.

### 1.10 Хүүхэд ба боловсрол


Налайх дүүргийн хэмжээнд 0-5 насны 1,529 хүүхэд цэцэрлэгт хамрагдаагүй (тухайн насны хүн амын 36%), 6-17 насны 348 хүүхэд (тухайн насны хүн амын 3%) сургуульд хамрагдаагүй байна. Дүүргийн хэмжээнд 0-5 насны хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдаагүй түвшин нийслэлийн дунджаас зургаан хувиар өндөр байна. 0-5 насны хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдаагүй түвшин 3-р хороонд (62%) хамгийн өндөр, харин 6-17 насны хүүхдүүдийн боловсролд хамрагдаагүй түвшин хамгийн их нь 7-р хороонд (13%) байна.

Хүүхдүүдийн ерөнхий нөхцөл байдлыг илүү өргөн хүрээнд судлахын тулд мэдээлэл нэгтгэгчээс хүүхдүүдэд тулгардаг үндсэн асуудал өөрсдийн хэсгийн нутаг дэвсгэр дээр хэр байгаа талаар асуусан. Налайх дүүргийн хэсгүүдийн 40 хувь нь боловсролтой холбоотой асуудал байхгүй гэж хариулсан бол 26 хувь нь сургуулиуд хэт хол байна гэж хариулжээ. Дүүргийн хэмжээнд хүүхдүүдтэй холбоотой хамгийн их бүртгэгдсэн хоёр асуудал бол хүүхдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх клуб, спортын төв дутмаг (хэсгүүдийн 36%) болон сургууль хэт хол (32%) байна.

Сургуульд хамрагдаагүй хүүхдүүд (хэсгийн эзлэх хувь)



Боловсролтой холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)



Хүүхдэд тулгамдаж буй үндсэн асуудлууд (хэсгийн эзлэх хувь)

